



**“УЛААНБААТАР БҮК” ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2015.04.22

№ХЭХ 2015-01

Улаанбаатар хот

“Улаанбаатар БҮК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал БГД, 20-р хороо, Дунд голын эрэг, өөрийн байрны хурлын танхимд 2015 оны 04-р сарын 22-ний өдрийн 11:00 цагт хувьцаа эзэмшигчдийг бүртгэж эхэлсэн ба хурал 11:12 минутанд эхлэв.

**Хурлын ирц:**

Тооллогын комиссын дарга Л.Нарандаваа танилцуулснаар:

“Улаанбаатар БҮК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд саналын эрхтэй 1 095 076 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 97 хувийг төлөөлсөн 5 хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн тул “Компанийн тухай хууль”-ийн 69.1 дэх заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

**Хэлэлцсэн асуудал:**

1/ 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.

2/ Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах

3/ ТУЗ-ын ердийн болон хараат гишүүдийг батлах.

4/ ТУЗ-ын төсөв батлах тухай

5/ Ногдол ашигийн талаархи ТУЗ-ын шийдвэр танилцуулах тухай

Хурлын даргаар ТУЗ-ын дарга Н. Хунцэнгэл ажиллав.

**Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч:** “УБ Менежмент” ХХК-ийн санхүү эрхэлсэн захирал Чапанов.М.А, “Титан Инвест” ХХК-ийн ажилтан Д.Сайнбаяр, хувьцаа эзэмшигч С. Мягмарсүрэн болон ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Н.Хунцэнгэл, хараат бус гишүүнд нэр дэвшигч М. Батбаатар, Д. Дэлэг “Улаанбаатар БҮК” ХК-ийн санхүү эрхэлсэн орлогч захирал Н. Энх-Оргил, ерөнхий инженер Твилинёв.В.В, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д. Байгалмаа нар хуралд оролцов.

Хурал даргалагч Н.Хунцэнгэл ээлжит хурлыг нээж, ээлжит хурал хуралдах тухай “Улаанбаатар БҮК” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 2015/07 тоот тогтоолыг товч танилцуулав.

“Улаанбаатар БҮК” ХК-ийн ТУЗ-ийн дарга Н.Хунцэнгэл хуралд хүрэлцэн ирсэн төлөөллийг танилцуулав.

**ТУЗ-ын дарга Н.Хунцэнгэл:**

Юуны өмнө хувьцаа эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн хүмүүсийг танилцуулья гэж бодож байна. Улаанбаатар БҮК ХК-ийн гүйцэтгэх захирал Мирзоев.Р.Г нь ОХУ-д томиллолтоор явж байгаа болно. Би өөрөөсөө эхлэн танилцуулья. Намайг Нямхүүгийн

Хунцэнгэл гэдэг. Би “Улаанбаатар БҮК” ХК-ийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна. Дараагийн хүн бол “Улаанбаатар БҮК” ХК-ийн санхүү эрхэлсэн орлогч захирал Н. Энх-Оргил гэж хүн байна. За мөн Улаанбаатар БҮК” ХК-ийн ТУЗ-н хараат бус гишүүн Д.Дэлэг, М.Батбаатар нар, Улаанбаатар БҮК” ХК-ийн ерөнхий инженер Твилинёв.В.В, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Байгалмаа, мэдээлэл өгөхөөр “Гендекс” ХХК-ийн ажилтан Болорцэцэг гэсэн хүмүүс ирсэн байна.

Хурлын дэг, хэлэлцэх асуудлыг танилцуулав.

**Хувьцаа эзэмшигч Мягмарсүрэн:** 2014 оны үйл ажиллагааг танилцуулна уу.

**Н. Энх-Оргил:** 2014 оны санхүүгийн тайланг танилцуулав. Түрээсийн үйл ажиллагаанаас нилээд ашиг олсон. 16,1 тэрбум борлуулалтын орлоготой, 3,9 тэрбум үйл ажиллагааны зардал. Үйл ажиллагааны зардал 1256 сая болсон. Балансад харсан байх элэгдлийн зардал тэр бум болсон, дахин үнэлгээ хийсэн байгаа. 745 сая төгрөгний ашигтай ажилласан. Аудитын дүгнэлт өчигдөр эцэслэн гарсан. 21 сая төгрөгний алдагдалтай гэсэн тайлан гарсан, энэхүү үзүүлэлтэнд 384 сая төгрөгний ханшийн зөрүүнээс хамааралтай зардал, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний элэгдлийн зардалтай холбоотой 200 сая төгрөгний зардал нөлөөлсөн. Аудит хийсэн тайлантай ТУЗ хараахан танилцаж амжаагүй болно.

Хувьцаа эзэмшигч Тэнгэр капитал:Аудитыг ямар компани гүйцэтгэсэн бэ

**Н.Энх-Оргил:** “Эрнэст энд Ян”ХХК-аар гүйцэтгүүлсэн.

ТУЗНБД Байгалмаа: Хувьцаа эзэмшигч “Улаанбаатар менежмент” ХХК-ийн төлөөлөгч Чапанов.М.А –д орчуулж өгье. Оросоор орчуулав.

“Улаанбаатар менежмент”ХХК-ийн санхүү эрхэлсэн захирал Чапанов.М.А:

Аудитын дүгнэлтээр тайланд засвар хийх шаардлагатай гэж үзэж байна. алдагдалтай тайлан гарах үндэслэлийг дахин тодруулна уу:

**Н.Энх-Оргил:** 210,0 сая төгрөгний зардал-үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний элэгдэл, 384,0 сая төгрөг-валютын зөрүүний зардал, 204,0 сая төгрөг-үл хөдлөх хөрөнгийн татварт ногдох зардал болсон.Эдгээрийг тооцоод 21,0 сая төгрөгний алдагдалтай тайлан гарч байна.

**Чапанов.М.А :** Аудитын дүгнэлт хэзээ гарч дууссан бэ

**Н.Энх-Оргил:** Өчигдөр хүлээн авсан, ТУЗ танилцаж ТУЗ-ийн дарга баталгаажуулах ёстой.

Хувьцаа эзэмшигчдээс татварт өгсөн тайлангаар ногдол ашиг хуваарилах тогтоолыг ТУЗ-ийн хурлаар дахин хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж байна.

**Хувьцаа эзэмшигч Мягмарсүрэн:** Саналыг яаж тооцох вэ

**Л. Нарандаваа:** хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

**Чапанов.М.А:** Аудитын тайлангаар алдагдалтай гарсан бол үл хөдлөхийн татварыг төлөх үү

**Н.Энх-Оргил:** Төлнө.

**Н. Хунцэнгэл:** Өөр санхүүгийн тайлангаас асуух зүйл байна уу

**Хувьцаа эзэмшигч “Тэнгэр капитал ҮЦК”ХХК :** Борлуулалтын орлого 81 хувиар өссөн байна. гол орлого нь ГОК-с орсон уу?

Том харилцагчдаа нэрлэж болох уу?

**Н.Энх-Оргил:** “Эрдэнэт ГОК”ХХК 10 тэрбум төгрөг, “Тэргүүн инвест”ХХК 1 тэрбум, “Самсунг”-тай тэрбумын гэрээ бий, одоо эхэлж байна. Хөшигтийн хөндийн төслийн туслан гүйцэтгэгч нар байгаа. 4-5 том компани байна.

**Хувьцаа эзэмшигч “Тэнгэр капитал ҮЦК”ХХК:** 2015 онд ямар төлөвлөгөөтэй байна?

**Н.Энх-Оргил:** Дээр дурдсан харилцагчидтай үргэлжүүлэн харилцана.

**Хувьцаа эзэмшигч Мягмарсүрэн :** 2015 оны санхүүгийн төлөвлөгөө бий юу

**Н.Энх-Оргил:** 3 тэрбумын гэрээ бий. Бетон дэр нийлүүлэх ажилд найдлага тавьж байна.

**Хувьцаа эзэмшигч “Тэнгэр капитал ҮЦК”ХХК:** Энэ жил хэвээр ажиллавал дараа жил бас алдагдалтай гарах уу

**Н.Энх-Оргил:** Технологийн дэвшил хийсэн. Элэгдлийн зардал буурвал ашигтай байж болно. Энэ жилд хамгийн сайн ажилласан. Үзүүлэлт эерэг гарсан, ажилчдын ур чадварын түвшин сайжирсан. Металл хийц дээр нарийн мэргэжилтнүүд нэмэгдсэн.Дундаж цалин 900 000-1,0 сая байгаа, жилийн 4 улиралд тасралтгүй ажилладаг.

Өрийг хувьцаагаар солих ажил дуусах шатандаа байна. СЗХнд материал өгсөн байгаа. Шийдвэр хүлээж байна. Энэ ажилд зөвлөгчөөр оролцож байгаа Гендекс ХХК –ийн төлөөлөгч тодорхой мэдээлэл өгнө , хагас жилийн тайланд орж ирэх байх. Хуучин өрнөөс мөн барагдуулсан, өр төлбөргүй гарах төлөвтэй байх .

**Чапанов.М.А:** Өрийг хувьцаагаар сольсны дараа хувьцааны үнэ яаж үнэлэгдэх вэ

**Гендекс ХХК-ийн төлөөлөгч Болорцэцэг:** 4 сарын 20-нд шийдвэр гарах байсан. СЗХ бүтцийн өөрчлөлт хийгээд одооноос хүмүүс нь ажлаа авч эхэлж байна гэсэн. Удахгүй хариу өгнө гэсэн хариуг өчигдөр өгсөн. Тэр шийдвэр гарсны дараа хорооны журмын дагуу саналын эрхтэй хувьцаа эзэмшигч нарт материал тараагдаад явагдана. Хорооны шийдвэрийг хүлээж байна.

**Чапанов.М.А:**Өрийг хувьцаагаар сольсны дараа нэгж хувьцааны үнийг яаж тогтоох вэ

**Гендекс ХХК-ийн төлөөлөгч Болорцэцэг:**Нэгж хувьцааны үнэ. 38700 төгрөгөөр тогтоосон байгаа.

**Чапанов.М.А:** Ямар зарчмаар тогтоосон бэ

**Н.Энх-Оргил:** Бизнесийн үнэлгээний компани нь орлогын хандлагын арга, хувьцааны сүүлийн саруудын дундаж үнэ, ирээдүйн хөрөнгийн өгөөж зэргийг тооцож тогтоосон.

**Чапанов.М.А:**Нэгж хувьцааны үнийг өрийг хувьцаагаар сольсны дараа өөрчлөх хуулийн зохицуулалт бий юу?

**Гендекс ХХК-ийн төлөөлөгч Болорцэцэг:** Байхгүй

**Чапанов.М.А:** 38700 төгрөгөөр хувьцааны үнийг тогтоолоо гэхэд “Улаанбаатар менежмент ХХК”өөрөөр үнэлэх эрх байгаа юу?

**Гендекс ХХК-ийн төлөөлөгч Болорцэцэг:** Байхгүй.

**Чапанов.М.А:** Энэ асуудлаар хуулийн зохицуулалт бий юу?

**Гендекс ХХК-ийн төлөөлөгч Болорцэцэг:** Арилжаанд оролцоод ханшийг өөрчилж болно. Бид нар шууд өөрчилж болохгүй.

**Хувьцаа эзэмшигч Мягмарсүрэн:** ногдол ашиг тараах талаар нэгэнт олон нийтэд мэдээлэл хүрсэн учраас төөрөгдүүлсэн болох вий.

**Хувьцаа эзэмшигч “Тэнгэр капитал ҮЦК”ХХК:** ТУЗ аудитын тайлантай танилцаад дүгнэлт хийнэ.

**Н.Энх-Оргил:** ТУЗ аудит хийсэн тайланг хэлэлцэхдээ энэ талаар шийдвэр гаргана байх.

Бидэнд хувьцаа эзэмшигчдийн хуралд аудит хийсэн тайланг танилцуулах хугацаа байгаагүй, аудит хийсэн тайлан хурлын материал тараахаас өмнө гараагүй. Бид нар хөрөнгийн бирж болон өөрийн байгууллагын сайтад танилцуулах болно. Өмнөх тайлан мөн сүүлд аудит хийсэн тайланг өнөөдрийн хуралд танилцууллаа. Аудит хийсэн тайлангийн тухайд ТУЗ танилцаж дүгнэлт гаргаагүй байгаа.

**ТУЗ-ын дарга Н. Хунцэнгэл:** Хувьцаа эзэмшигчид саналаа саналын хуудсын дагуу өгнө, өөр асуудал байхгүй бол дараагийн асуудлыг хэлэлцэх үү

Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг танилцуулья. Угсармал орон сууц, төмөр бетон эдлэл, бетон зуурмаг үйлдвэрлэх гэсэн үйл ажиллагааны чиглэл компанийн дүрэмд тжсгагдсан. Бизнесийн чиглэлээр бусад байгууллагатай гэрээ байгуулан ажиллах, тендерд орох гэх мэтчилэн үйл ажиллагаанд Компани оролцоход хуулийн этгээдийн гэрчилгээнд нэмж тусгагдсан гэрчилгээ шаардлагатай учраас компанийн дүрэмд өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа. Иймд дараахи үйл ажиллагааны чиглэлээр тусгай зөвшөөрөл авсан тул Улсын бүртгэлийн гэрчилгээнд шинээр нэмэх шаардалагтай байгаа болно.

**Хувьцаа эзэмшигчдийн зүгээс:** Санал болон асуулт байхгүй гэв.

**ТУЗ-ын дарга Н. Хунцэнгэл:** Асуулт байхгүй бол дараагийн асуудлыг хэлэлцье. ТУЗ-н гишүүд сонгох. Гишүүдийг товч танилцуулав.

Ердийн болон хараат гишүүдийн намтар, мэргэжил боловсролын байдлыг танилцуулав.

Үүн дээр санал хураах саналтай байна. Асуулт хариулт байна уу?

**Хувьцаа эзэмшигч “Тэнгэр капитал ҮЦК”ХХК:** Хараат бус гишүүдээс асуух зүйл байна:

Хараат бус гишүүдээс Хувьцаа эзэмшиж байгаа юу, барилгын салбарт ажиллаж байсан туршлагатай гэж танилцуулгаас харагдаж байна, компанийн үнэ цэнийг дээшлүүлэхэд яаж нөлөөлж байна вэ? Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах талаар үйл ажиллагаа явуулж байна уу?

**ТУЗХБГ Д.Дэлэг:** Тоног төхөөрөмж шинээр сонгож нийлүүлэхэд урьдчилж санал өгөх, ажилчдын мэргэжил дээшлүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэх төсөл боловсруулах, технологийн шаардлага материалын чанарын удирдлагын системийг сайжруулах талаар санал оруулж ажиллаж байна. Судалгаатай ажиллаж байна. ШУ үйлдвэрлэлийн чиглэлээр шинэ асуудлууд нэвтрүүлэх бодлоготой. Би 16 жил барилга хот байгуулалтын зөвлөлд ажилладаг учраас мэдээлэл солилцох гэх мэт ажлууд бий. Төмөр замын газрын даргын зөвлөхөөр 4 жил ажилласан туршлага маань бетон дэрний үйлдвэрлэлийн бодлогод нөлөөлсөн гэж үзэж байна .

**ТУЗХБГ М. Батбаатар:** Шинэ технологи нэвтрүүлэх, бетон үйлдвэрлэл чиглэлээр нэлээд бодлогоор дэмжиж ажилладаг. Жижиг хувьца эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд үйлчлэх зорилгоор ТУЗ-ын бүрэлдэхүүнд орж ажилладаг.

**ТУЗ-ын дарга Н. Хунцэнгэл:** Дараагийн асуудал, Төсөв батлах тухай. ТУЗ-ийн 2015 оны төсөв танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдэд санал асуулт байхгүй гэв.

ТУЗ-ын дарга Н. Хунцэнгэл: Өөр асуулт байхгүй бол саналын хуудсаа тоолох ажилдаа орё.

Тооллогын комиссын дүнг үндэслэн дараах шийдвэр гаргав:


*Тооллогын комиссын дүнг үндэслэн хурлаас шийдвэрлэсэн нь:*

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлав. Хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0% нь татгалзсан, 0% нь түдгэлзсэн байна.
2. Ногдол ашгийн талаар ТУЗ-ийн шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав. Тайланд аудит хийсэнтэй холбоотойгоор ТУЗ-ын хурлаар аудит хийсэн тайланг хэлэлцсний дараа шийдвэр гаргаж хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхээр тогтов.
3. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг 100 хувийн саналаар батлав.
4. ТУЗ-ын ердийн болон хараат гишүүнд нэр дэвшсэн 9 хүнийг 100 хувийн саналаар батлав. Кумулятив аргаар санал өгөх хувьцааны тоо 9 855 684. Тооллогод нийт хувьцаа эзэмшигчдийн 97 хувь буюу 1 095 076 ширхэг хувьцаа эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийн 5 саналын хуудас ирснээс 5 нь хүчинтэй байлаа.
5. ТУЗ-ын төсвийг 100 хувийн саналаар батлав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолыг Хурлын дарга танилцуулж хурлыг хаав.

Хурал 13цаг 10 минутад дуусав.

Протокол хөтөлсөн:

 Л. Нарандаваа